



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/287.

Чойр

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хайсу овогт Энхтайваны Мөнхзул нь /ЛД75110405/ Сүмбэр сумын 3 дугаар багт Найрамдал хотхон 45-61 тоотод байрлах гараашийн зориулалттай 22м² газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулах хүсэлт гаргасан тул гараашийн зориулалтаар 40 жилийн хугацаатайгаар сунган эзэмшүүлсүгэй.


2.Хуулийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулан авч буй иргэн Э.Мөнхзулд газрынхаа орчны тохижилтыг сайжруулж, зүй зохистой ашиглахыг үүрэг болгосугай.

3.Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг хуулийн дагуу сунгаж буй иргэн Э.Мөнхзултай газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Отгончимэг)-д үүрэг болгосугай.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны А/317 дүгээр захирамжийн 2 дахь бүртгэлийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  Г.БАТЗАМ





Аймгийн Засаг даргын 2022 оны
... сарын-ны өдрийн.....дугаар
захирамжийн хавсралт

Хайсу овогт Энхтайваны Мөнхзулын эзэмшил газрын
хугацааг сунгаж буй газрын байршлын зураг

| Сумын нэр | Багийн дугаар | Газрын хэмжээ /м ² / | Эзэмших хугацаа /жил/ | Газрын зориулалт | Газрын байршил, нэр |
|-----------|---------------|---------------------------------|-----------------------|------------------|-------------------------------|
| Сүмбэр | 3 | 22 | 40 | Гарааш | Найрамдал хотхон 45-Г/61 тоот |

